МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК


1 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

1.1 Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт


Мөнгөний нийлүүлэлт (М2 мөнгө) өмнөх оны мөн үеэс ***4.2 хувиар өсч 26.5 их наяд төгрөгт хүрлээ.*** М2 мөнгөний жилийн өсөлтийн 5.6 нэгж хувийг төгрөгийн харилцах, 2.0 нэгж хувийг гадаад валютын харилцах, -2.6 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, -0.7 нэгж хувийг гадаад валютын хадгаламж тус тус бүрдүүлж байна *(Зураг 1-1).*

Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 246.5 тэрбум төгрөгөөр өсөхөд иргэд, хувийн байгууллагын гадаад валют, төгрөгийн харилцах болон гадаад валютын хадгаламж тус тус өссөн нь голлон нөлөөллөө *(Зураг 1-2).*

Зураг 1-1: М2 мөнгө өмнөх оны мөн үеэс 4.2%-иар нэмэгдэв.



Зураг 1-2: М2 мөнгө өмнөх сараас 246.5 тэрбум төгрөгөөр буюу 0.9%-иар өсөв.




1.2 Хадгаламж

Нийт хадгаламжийн хэмжээ 18.0 их наяд төгрөг байгаагаас 88.4 хувь буюу 15.9 их наяд төгрөг нь иргэдийн, 11.6 хувь буюу 2.1 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 23.8 хувь нь гадаад валютын хадгаламж байгаа бөгөөд байгууллагын хадгаламжийн 37.7 хувийг, иргэдийн хадгаламжийн 22.0 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна *(Зураг 1-3).*


1.3 Мөнгөний нийлүүлэлтийн байршуулалт

Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 25.3 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 1.2 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үеэс М2 мөнгөний өсөлтийн 26.4 нэгж хувийг ДЦА, -22.1 нэгж хувийг ГЦА бүрдүүлжээ *(Зураг 1-4).* ДЦА-ын өсөлтөд банкуудын зээлийн өсөлт голчлон нөлөөлж байна.

Зураг 1-3: Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 4.4%-иар буурав.



Зураг 1-4: М2 мөнгөний жилийн өсөлтөд ДЦА-ын өсөлт эерэгээр нөлөөлж байна.




Эх сурвалж: Монголбанк

2 БАНКУУДЫН ЗЭЭЛ


2.1 Зээлийн өсөлт

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс ***25.2 хувиар өсч 21.9 их наяд төгрөгт хүрсэн*** байна. Тодруулбал өмнөх оны мөн үеэс хувийн байгууллагын зээл 26.2 хувиар өсч 10.2 их наяд төгрөгт, иргэдийн зээл 27.2 хувиар өсч 11.3 их наяд төгрөгт хүрчээ *(Зураг 2-1)*. Нийт зээлийн үлдэгдлийн 1.4 их наяд төгрөг буюу 6.6 хувь нь гадаад валютаар олгосон зээл байна. Өмнөх сартай харьцуулахад зээлийн үлдэгдэл 797.0 тэрбум төгрөг буюу 3.8 хувиар өссөн бөгөөд хувийн байгууллагын зээл 2.9 хувиар, иргэдийн зээл 4.5 хувиар тус тус өсчээ. Харин банкуудаас МИК ОССК-д шилжүүлсэн иргэдийн ипотекийн зээлийг нэмж тооцвол нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 21.2 хувиар, өмнөх сараас 3.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг 2-1: Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар өсч 21.9 их наяд төгрөг болов.



Зураг 2-3: Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 1,324.4 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 837.0 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.




2.2 Зээл олголт, эргэн төлөлт

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 1,324.4 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 837.0 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.*(Зураг 2-3)*. Шинээр олгосон зээлийн 5.7 хувь буюу 179.4 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

2.3 Чанаргүй зээл


Чанаргүй зээл өмнөх сараас 32.9 тэрбум төгрөгөөр буурч ***2,117.1 тэрбум төгрөгт*** хүрлээ. Чанаргүй зээлийн 26.7 хувийг уул уурхайн салбар, 18.1 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 13.7 хувийг барилга, 8.0 хувийг цалин, тэтгэвэр, 7.5 хувийг үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын зээл тус тус эзэлж байгаа бөгөөд нийт чанаргүй зээлийн 8.9 хувь нь гадаад валютаар олгосон зээл байна. Чанаргүй зээлийн 77.3 хувийг, анхаарал хандуулах зээлийн 78.9 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлж байна *(Зураг 2-4)*.

Зураг 2-2: Нийт зээлийн 9.7% нь чанаргүй зээл, 4.4% нь анхаарал хандуулах зээл байна.



*Тайлбар: * үйл ажиллагаа явуулж буй 11 банкаар*

Зураг 2-4: Чанаргүй зээлийн 58.4%-ийг уул уурхай, боловсруулах, барилга болон үл хөдлөх хөрөнгийн салбар эзэлж байна.



Эх сурвалж: Монголбанк

2.4 Хувийн байгууллагын зээл

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 286.3 тэрбум төгрөгөөр өсчээ. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн сарын өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан харуулбал, бөөний болон жижиглэн худалдааны салбарын зээл 155.9 тэрбум, барилгын салбарын зээл 85.1 тэрбум, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарын зээл 19.4 тэрбум, тээвэр агуулахын үйл ажиллагааны салбарын зээл 17.0 тэрбум, уул уурхайн салбарын зээл 16.4 тэрбум төгрөгөөр тус тус өсч, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээл 16.9 тэрбум, ХАА-н салбарын зээл 5.3 тэрбум, ус хангамжийн салбарын зээл 4.9 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.


Тайлант сард хувийн байгууллагад 1,475.3 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 11.6 хувь буюу 170.7 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл гадаад валютаар олгогджээ *(Зураг 2-5)*.

2.5 Иргэдийн зээл


Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 480.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тодруулбал, өмнөх сараас хадгаламж барьцаалсан зээл 124.8 тэрбум, худалдааны салбарын зээл 76.7 тэрбум, ипотекийн зээл 70.9 тэрбум (*МИК-д шилжсэн багцыг оруулснаар*), цалингийн зээл 47.9 тэрбум, тэтгэврийн зээл 44.7 тэрбум, малчны зээл 25.9 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Харин автомашины зээл 2.7 тэрбум, уул уурхайн салбарын зээл 2.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна *(Зураг 2-6)*.

Тайлант сард иргэдэд 1,517.4 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 0.6 хувь нь гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-5: Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, уул уурхай болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээл бүрдүүлж байна.



Зураг 2-6: Иргэдийн зээлийн үлдэгдлийн 41.0% (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар)-ийг орон сууцны зээл, 23.0%-ийг цалин, тэтгэврийн зээл бүрдүүлж байна.




Зураг 2-7: Тайлант сард хувийн байгууллагад худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт дийлэнх зээл олгогдсон байна



**Цахилгаан хий, усан хангамж, газар тариалан, мэдээлэл холбоо, санхүү даатгал, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд*

Зураг 2-8: Тайлант сард иргэдэд олгосон зээлийн ихэнх хувийг цалин, тэтгэврийн зээл болон хадгаламж барьцаалсан зээл бүрдүүлж байна.



**ХАА, газар тариалан, боловсруулах, цахилгаан хий, усан хангамж, тээвэр агуулах, үйлчилгээ, мэдээлэл холбоо, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд*

Эх сурвалж: Монголбанк

2.6 ЖДҮ зээл

ЖДҮ эрхлэгчдийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс ***26.8 хувиар өсч 5.5 их наяд төгрөгт хүрсэн*** байна *(Зураг 2-9)*. Үүний 57.8 хувь буюу 3.2 их наяд төгрөгийг ЖДҮ эрхлэгч ААН-д, 42.2 хувь буюу 2.3 их наяд төгрөгийг ЖДҮ эрхлэгч иргэдэд тус тус олгожээ.


ЖДҮ эрхлэгчдийн зээлийн үлдэгдлийн 39.8 хувийг худалдаа, 11.6 хувийг барилга, 10.7 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 4.2 хувийг байр сууц, нийтийн хоолны үйлчилгээ, 3.7 хувийг ХАА-н салбарын зээл бүрдүүлж байна *(Зураг 2-10)*.

Өмнөх сартай харьцуулахад ЖДҮ эрхлэгчдийн зээлийн үлдэгдэл 70.6 тэрбум төгрөгөөр буюу 1.3 хувиар өсчээ.


ЖДҮ эрхлэгчдийн зээлийн үлдэгдлийн 10.2 хувь нь чанаргүй, 3.3 хувь нь анхаарал хандуулах ангилалд байна. Анхаарал хандуулах зээл өмнөх сараас 16.4 хувиар, чанаргүй зээл 2.0 хувиар тус тус буурчээ. Тайлант сард ЖДҮ эрхлэгчдэд ***560.4 тэрбум төгрөгийн зээл*** олгосон нь өмнөх оны мөн үеэс ***20.1 хувиар буурч,*** өмнөх сараас ***125.7 хувиар өсчээ.*** Тайлант сард олгосон зээлийн 42.7 хувийг худалдаа, 9.2 хувийг барилга, 3.7 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 3.1 хувийг байр сууц, нийтийн хоолны үйлчилгээ, 2.4 хувийг ХАА-н салбарт тус тус олгосон байна *(Зураг 2-11)*.

ЖДҮ эрхлэгч ААН-ийн зээлийн үлдэгдлийн 41.8 хувь нь дунд, 31.5 хувь нь жижиг, 26.7 хувь нь бичил ААН-д тус тус ногдож байна (*Зураг 2-12*).

Зураг 2-9: ЖДҮ зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 26.8 хувиар өсчээ.




Зураг 2-10: ЖДҮ эрхлэгч ААН-ийн зээлийн үлдэгдлийн 30.4 хувийг, иргэдийн зээлийн үлдэгдлийн 52.7 хувийг худалдааны салбарын зээл бүрдүүлж байна.




Тайлбар: ААН болон иргэдийн ЖДҮ-ийн зээлийн бүтцийг харуулав

Зураг 2-11: ЖДҮ эрхлэгчдийн чанаргүй ангиллын зээлийг салбараар задлан харвал ААН-ийн зээлийн 33.5 хувь, иргэдийн зээлийн 8.9 хувь нь боловсруулах салбарын зээл байна.



Тайлбар: ААН болон иргэдийн чанаргүй ангиллын зээлийг салбараар харуулав

Зураг 2-12: ЖДҮ эрхлэгч ААН-ийн зээлийн үлдэгдлийн 41.8 хувь нь дунд ААН-д ногдож байна.



Эх сурвалж: Монголбанк

3 ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

3.1 Ипотекийн зээлийн үлдэгдэл

Ипотекийн зээлийн үлдэгдэл 2022 оны 3 дугаар сарын байдлаар ***104,784 зээлдэгчийн нийт 5,800.3 тэрбум төгрөг*** байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 80,765 зээлдэгч 4,348.8 тэрбум төгрөгийн зээл авсан байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.0 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 22.5 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.5 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна *(Зураг 3-1)*.

3.2 Орон сууцны байршил

Нийт ***ипотекийн зээлийн 16.6 хувь буюу 965.5 тэрбум төгрөгийн зээл орон нутагт*** ногдож байна. Орон нутгийн ипотекийн зээл[1]-ийн 77.1 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.6 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 1.3 хувь нь бусад эх үүсвэрээр олгогджээ *(Зураг 3-4)*.


3.3 Ипотекийн зээлийн чанарын үзүүлэлт

Нийт ипотекийн ***зээлийн үлдэгдлийн 97.1 хувь нь хэвийн***, 0.9 хувь нь анхаарал хандуулах, 1.8 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 67.6 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 31.7 хувийг хөтөлбөрийн зээл, 0.7 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна *(Зураг 3-2)*.

3.4 Эх үүсвэр

Тайлант сард ***1,166 зээлдэгчид (үүнээс хөтөлбөрийн хүрээнд 609 зээлдэгчид) 122.2 тэрбум төгрөгийн*** ипотекийн зээл шинээр олгосон бөгөөд үүний 43.8% хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна *(Зураг 3-3)*.

Зураг 3-1: Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 15.5% байна.




Зураг 3-2: Өмнөх сараас анхаарал хандуулах зээл 2.2 тэрбум төгрөгөөр өсч, чанаргүй зээл 10.0 тэрбум төгрөгөөр буурав.



Зураг 3-3: Тайлант сард 122.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгожээ.



Зураг 3-4: Нийт зээлийн 16.6% буюу 965.5 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.



Эх сурвалж: Монголбанк

[1] Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.


3.5 Ипотекийн зээлийн хүү

Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 2.3 нэгж хувиар өсч, өмнөх сараас 0.4 нэгж хувиар буурч 10.2 хувьд хүрсэн байна *(Зураг 3-5)*.


3.6 Барьцаа хөрөнгө

Ипотекийн зээлээр ***борлуулагдсан орон сууцны 85.8 хувийг 80 хүртэлх м.кв талбайтай*** байр бүрдүүлж байна *(Зураг 3-6)*.

Зураг 3-5: Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 10.2 хувьтай байна..



Зураг 3-6: Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ талбайн хэмжээгээр




3.7 Орон сууцууд ашиглалтад орсон оноор

Ипотекийн зээлээр ***борлуулагдсан орон сууцны 77.3 хувийг 2011 оноос хойш*** баригдсан орон сууц бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь нийт ипотекийн зээлийн 82.3 хувийг эзэлж байна *(Зураг 3-7)*.


3.8 Зээлдэгчдийн орлогын тархалт

Өрхийн орлого нь 2.5 сая төгрөг хүртэлх иргэд нь нийт зээлдэгчдийн 69.0 хувийг, нийт зээлийн үлдэгдлийн 54.8 хувийг тус тус бүрдүүлж байна *(Зураг 3-8)*.

Зураг 3-7: Ипотекийн зээлийн үлдэгдлийн 82.3 хувийг 2011 оноос хойш ашиглалтад орсон орон сууц бүрдүүлж байна.



Зураг 3-8: Ипотекийн зээлдэгчдийн 69.0 хувийг сарын өрхийн орлого нь 2.5 сая төгрөг хүртэлх иргэд бүрдүүлж байна.



Эх сурвалж: Монголбанк

4 ХҮҮ

4.1 Шинээр татсан хадгаламжийн хүү

Тайлант сард шинээр татсан ***төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 6.7 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 2.1 хувь*** байна *(Зураг 4-1)*. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх сараас 0.2 нэгж хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар буурсан бол валютын хадгаламжийн ЖДХ харгалзан 0.4 болон 0.2 нэгж хувиар мөн буурчээ.

4.2 Хүүний зөрүү


Шинээр татсан төгрөгийн хадгаламж болон шинээр олгосон төгрөгийн зээлийн ***хүүний зөрүү 7.8 нэгж хувьд*** хүрэв *(Зураг 4-3)*.

4.3 Шинээр олгосон зээлийн хүү


Тайлант сард ***шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 14.6 хувь***, ***гадаад валютын зээлийн ЖДХ 8.4 хувьд*** хүрчээ *(Зураг 4-2)*. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төгрөгийн зээлийн хүү 0.8 нэгж хувиар, валютын зээлийн хүү 0.2 нэгж хувиар буурчээ.

Иргэдэд олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 14.9 хувь, хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 14.3 хувь байна.


Зураг 4-1: Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх сараас 0.2 нэгж хувиар өсөв.




Зураг 4-2: Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү өмнөх сараас 0.2 нэгж хувиар өсөв.



Зураг 4-3: Хадгаламж, зээлийн хүүний зөрүү өмнөх оноос 0.7 нэгж хувиар буурчээ.



Зураг 4-4: Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүний тархалт




Эх сурвалж: Монголбанк


4.4 Үлдэгдлээрх хадгаламжийн хүү

Нийт төгрөгийн ***хадгаламжийн үлдэгдэлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурч 7.2 хувьд*** хүрчээ. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурч 2.1 хувьд хүрчээ. Иргэдийн төгрөгийн хадгаламжийн ЖДХ 7.3 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 2.2 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн ЖДХ 6.5 хувь байна *(Зураг 4-5)*. Үлдэгдлээрх нийт төгрөгийн хугацаат хадгаламжийн хүү 8.7 хувь байгаа бол бүх төрлийн хугацаагүй хадгаламжид хүү тооцогдохгүй[2] байгаа болно *(Зураг 4-7)*.

Зураг 4-5: Үлдэгдлээрх иргэдийн хугацаат хадгаламжийн ЖДХ төгрөгийнх 8.8 хувь, валютынх 2.8 хувь байна.



Зураг 4-7: Нийт төгрөгийн хадгаламжийн 16.5 хувь нь хугацаагүй байршиж байна.




4.5 Зээлийн үлдэгдлээрх хүү


Төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 15.4 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 9.4 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 15.9 хувь, гадаад валютынх 12.8 хувь байна. Хувийн байгууллагын төгрөгийн зээлийн ЖДХ 14.7 хувь, гадаад валютынх 9.6 хувь байна *(Зураг 4-6)*.

Нийт хэвийн зээлийн үлдэгдлийн 45.9 хувь нь 2 хүртэлх жилийн дотор төлөгдөж дуусах зээл байна *(Зураг 4-8)*.

Зураг 4-6: Иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн хүү өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар буурчээ.



Зураг 4-8:Энгийн зээлийн үлдэгдэл, хугацаагаар



[2] "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт "Цар тахлын үед банкны хугацаагүй хадгаламжид хүү тооцохгүй байхаар зохицуулсантай холбоотойгоор 2021.01.29-2022.06.30 өдрийг дуустал бүх төрлийн хугацаагүй хадгаламжид хүү тооцохгүй.

5 ИНФЛЯЦ


5.1 Улсын инфляц

Улсын индекс 2022 оны 3 дугаар сарын байдлаар 0.8 хувь, ***жилийн инфляц 14.4 хувь*** байна. Жилийн инфляцыг авч үзвэл 9.5 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 4.9 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна *(Зураг 5-1)*.


5.2 Улаанбаатар хотын инфляц

Улаанбаатар хотын инфляц 3 дугаар сарын байдлаар сарын 0.9 хувь, ***жилийн инфляц 15.8 хувь*** байгаа бөгөөд үүний 10.5 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 5.3 нэгж хувийг хүнсний бараа бүрдүүлж байна. Хүнсний бүлгийн үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт, хүнснээс бусад барааны үнийн өсөлтөд бензин үнэ өссөн нь голлон нөлөөлжээ *(Зураг 5-2)*.

Зураг 5-1: Улсын жилийн инфляц 14.4 хувьтай байна.



Зураг 5-2: УБ хотын жилийн инфляц 15.8 хувьд хүрэв.



Эх сурвалж: УСХ


5.3 Улаанбаатар хотын хүнсний барааны жилийн инфляц

Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс ***18.9 хувь өсч*** инфляцын ***5.3 нэгж хувийг*** бүрдүүлжээ. Үүний 1.8 нэгж хувийг мах, махан бүтээгдэхүүн, 1.1 нэгж хувийг талх, гурил, будаа, 1 нэгж хувийг хүнсний ногоо, 0.3 нэгж хувийг сүү, өндөг, 1.1 нэгж хувийг бусад хүнс нийт үнийн өсөлт тус тус бүрдүүлж байна *(Зураг 5-3)*.


5.4 Улаанбаатар хотын хүнсний бус барааны жилийн инфляц

Хүнснээс бусад барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс ***15.1 хувь өсч*** инфляцын ***10.5 нэгж хувийг*** бүрдүүлжээ. Үүний 2.6 нэгж хувийг бензин, 1.8 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, 1.5 нэгж хувийг хувцас, бөс бараа болон гутал, 0.8 нэгж хувийг зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ, 0.7 нэгж хувийг эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ, 0.5 нэгж хувийг согтууруулах ундаа, тамхи , 2.6 нэгж хувийг бусад хүнс нийт бүлгийн үнийн өсөлт тус тус бүрдүүлж байна *(Зураг 5-4)*.

Зураг 5-3: Хүнсний барааны бүлгийн УБ хотын жилийн инфляцын 5.3 нэгж хувийг бүрдүүлэв.



Зураг 5-4: Хүнсний бус барааны бүлгийн УБ хотын жилийн инфляцын 10.5 нэгж хувийг бүрдүүлэв.




Эх сурвалж: УСХ

6 ХАНШ

6.1 Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш сарын эцсийн байдлаар 2948.46 төгрөгт хүрсэн нь ***өмнөх сарын эцсээс 2.9 хувиар***, ***өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар*** суларсан үзүүлэлттэй байна. Тайлант сарын дундаж ханш нь 2901.83 төгрөг байв *(Зураг 6-1)*.


Зураг 6-1: Төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн өөрчлөлт.



6.2 Төгрөгийн юантай харьцах ханш

Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш ***өмнөх сараас 2.4 хувиар***, ***өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар*** суларч 464.78 төгрөгт хүрэв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 453.58 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 464.78 төгрөг байлаа *(Зураг 6-2)*.

Зураг 6-2: Төгрөгийн юаньтай харьцах ханшийн өөрчлөлт.



Эх сурвалж: Монголбанк


ХАВСРАЛТ

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. М2 мөнгөний сарын өсөлт




Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




2. ЗЭЭЛ


Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа, секторын ангиллаар




Зураг 2.3. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа, салбарын ангиллаар




Зураг 2.4. Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлтийн задаргаа, салбарын ангиллаар




Зураг 2.5. Тайланд сард шинээр олгосон, төлөгдсөн зээл




Зураг 2.6. Тайлант сард шинээр олгосон зээл, салбарын ангиллаар




Зураг 2.7. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. Чанаргүй зээлийн дүн, салбарын ангиллаар




Зураг 2.9. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл, салбарын ангиллаар




Зураг 2.10. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбарын ангиллаар




Зураг 2.11. Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц, салбарын ангиллаар



Зураг 2.12. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.13. Орон нутгийн зээлийн үлдэгдэл




Зураг 2.14. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь, аймаг тус бүрээр




3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Зураг 3.1. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар



Зураг 3.2. Тухайн сард нийслэл хотод олгогдсон ипотекийн зээл, дүүргээр



Зураг 3.3. Тухайн сард орон нутагт олгогдсон ипотекийн зээл, орон сууцны байршлаар



Зураг 3.4. Ипотекийн зээл насны ангиллаар

